



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 02 сарын 27 өдөр

Дугаар

А/12

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын газрын
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1 дэх хэсэг, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

4. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.


5. Тушаалын үнэт цаасны бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 2 сарын 24 өдрийн
тоот тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН
НЭГЖИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

2014.02.27

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Бод-Энх ХХК	Очир	Баянгол дүүрэг, 17-р хороо, Жалханз хутагт Дамдинбазарын гудамж
2	Келсо ХХК	Келсо	Баянгол дүүрэг, 4-р хороо, П.Жасрайн гудамж 27-1
3	Айвантайшир ХХК	Чилүгэн	Баянгол дүүрэг, 18-р хороо, Энэбишийн гудамж
4	Корпорейт хотел ХХК	Корпорейт	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 9-2
5	Хүннү палас ХХК	Хүннү палас	Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, Их тойруу 13

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 2 сарын 24 өдрийн
А/2 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ИРГЭН,
АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ЖАГСААЛТ


2014.02.27

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Жинст Чачирт ХХК	Есөн Енбүү	Сонгинохайрхан дүүрэг, 27-р хороо, Баянхошууны гудамж 15/1
2	Нью Энкис ХХК	Тулга	Баянгол дүүрэг, 3-р хороо, Замчдын гудамж-3
3	Торгон нутаг ХХК	Түшиг	Баянзүрх дүүрэг, 24-р хороо, Эрдэнэ толгойн 1-37
4	Мөн чипс ХХК	Сити	Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө13

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 2 сарын 27 өдрийн
А/а тоот тушаалын хоёрдугаар хавсралт



АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ИРГЭН,
АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ЖАГСААЛТ

2014.02.27

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Баянзүрх Шижир ОНӨҮГ	Баянзүрх Шижир	Баянзүрх дүүрэг, 20-р хороо, Шижирийн ам

-ooOoo-